

ОЮУТНЫ ДЭЛХИЙН АВАРГЫН МӨНГӨН МЕДАЛЫТ, ОУХМ Ц.БАТ-ЭРДЭНИЙ
НЭРЭМЖИТ ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН БАГА НАС, ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУД, НАСАНД
ХҮРЭГЧДИЙН “АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ АНХДУГААР ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН

Олимпын таеквондогийн аймгийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээн Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газарт 2022 оны 3 дугаар сарын 5-нд бага нас, өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн ангилалаар 22 жинд хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Тэмцээнд Эрдмийн далай цогцолбор сургууль, Мандал сургууль, Говийн ирээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургууль, Цэгц билиг сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хулд сум, Дэлгэрцогт сум, 3-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэгийн нийт 12 байгууллагын 120 гаруй тамирчид оролцлоо.

Тэмцээнийг Таек-вон софт шүүлтийн системийг ашиглан Монголын таеквондогийн холбооны Улсын шүүгчид шүүн явуулснаараа онцлог боллоо.

Тэмцээний шилдэгүүдээр:

- ЭДЦС-ын сурагч П.Мөнх-Оргил
- ЭДЦС-ын сурагч Э.Гэгээнээ
- ЭДЦС-ын сурагч Д.Амгалантөр
- ГИЦС-ын сурагч Э.Хонгорзул
- ГИЦС-ын сурагч О.Батням
- Их засаг сургуулийн оюутан А.Азжаргал нар тус тус шалгарлаа.

Багийн дүнгээр:

1-р байр-А.Ууганцэрэн дасгалжуулагчтай ЭДЦСургууль

2-р байр- П.Ууганбаяр дасгалжуулагчтай Мандал сургууль

3-р байр- Б.Баасандорж дасгалжуулагчтай Хүмүүнлэг сургуулиуд шалгарлаа.

Насанд хүрэгчдийн ангилалаас 2022 оны 6 дугаар сард зохион байгуулагдах Монголын Бүх Ард Түмний Спортын XV наадамд оролцох тамирчдыг сонгон шалгарууллаа.

Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаанд Дундговь аймгийн таеквондогийн холбооны тэргүүн Б.Доржсүмбэр, Биеийн тамир, спортын газрын дарга А.Отгонбаатар, аймгийн тагнуулын газрын дарга Б.Мөнхбат, Мобикомын салбарын захирал У.Тамир, БТСГазрын НБТХМэргэжилтэн С.Цолмон, “Говийн заг” ТББ-ын тэргүүн Р.Чинбаатар нар хүрэлцэн ирж баг тамирчдад хүндэтгэл үзүүллээ.

Тэмцээнийг ивээн тэтгэж дэмжлэг үзүүлсэн У.Тамир захиралтай дундговь аймгийн Мобикомын хамт олон, А.Отгонбаатар даргатай БТСГазрын хамт олон, Э.Чагнаадорж даргатай Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хамт олонд нийт баг тамирчид, холбооны нэрийн өмнөөс баярласан талархсанаа илэрхийлье!































Тэмцээнийг ивээн тэтгэж дэмжлэг үзүүлсэн У.Тамир захиралтай дундговь аймгийн Мобикомын хамт олон, А.Отгонбаатар даргатай БТСГазрын хамт олон, Э.Чагнаадорж даргатай Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хамт олонд нийт баг тамирчид, холбооны нэрийн өмнөөс баярласан талархсанаа илэрхийлье!

Тайлан бичсэн мэргэжилтэн

С.Цолмон